

# ТӨРИЙН АЛБАНААС ҮНДЭСЛЭЛГҮЙ ЧӨЛӨӨЛСӨН ТАЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

## Нэг. Өргөдлүүдийн тухай

Улсын Их Хурал, Өргөдлийн байнгын хороонд 2014-2015 онд төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүйгээр халсан, чөлөөлсөн тухай нийт **227** /Нээлттэй сонсголын үеэр 179 байсан/ иргэнтэй холбоотой өргөдлүүд ирсэн. Эдгээр өргөдлүүдийг төрийн байгууллагаар нь авч үзвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 8 яам, 7 агентлаг, 10 нутгийн захиргааны байгууллагаас үндэслэлгүйгээр халагдсан, чөлөөлөгдсөн байна.

Төрийн байгууллагаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн талаар гомдол гаргасан өргөдлүүдийг агуулгаар нь түүвэрлэвэл:

- 20-30 хүнийг нэг дор олноор чөлөөлсөн талаар /30 аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга, 17 Голын сав газрын дарга, 27 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дарга нар/
- Албан тушаалын чиг үүрэг нь хэвээр үлдсэн байхад албан тушаал, газар хэлтсийн нэрийг бага зэрэг өөрчлөн бүтцийн өөрчлөлт нэрийдлээр чөлөөлсөн талаар /Жишээлбэл: Эрүүл мэнд, спортын яамны Бодлого төлөвлөлтийн газрыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газар болгон өөрчилж газрын даргыг чөлөөлсөн/
- Түр орлон гүйцэтгэгч Төрийн нарийн бичгийн дарга нар хууль бусаар ажлаас чөлөөлсөн талаар /ЭМСЯ, БОНХАЖЯ Төрийн нарийн бичгийн дарга нартай холбоотой/
- Баянхонгор, Булган аймгийн сумдын Мал, эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүдийн орон тоог хассан тухай ХХААЯ, Сангийн яамнаас шийдвэр гаргаагүй байхад орон нутгийн удирдлагууд дур мэдэн орон тоог хасаж, төрийн албан хаагчдыг чөлөөлж байгаа талаар
- Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан тухай бүх шатны шүүхээр тогтоогдон ажилд нь эргүүлэн томилох шийдвэр гарсан боловч шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа эсвэл ажилд нь эргүүлэн аваад маргааш нь, хэд хоногийн дараа дахин чөлөөлж байгаа талаар. /Дархан-Уул аймгийн "Оюуны ирээдүй" цогцолбор сургуулийн захирлын албан тушаал эрхэлж байсан А.Нарантуяаг ажилд нь эргүүлэн томилох бүх шатны шийдвэр гарсан боловч 2013 оноос хойш Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Хүний эрхийн үндэсний комисс, Өргөдлийн байнгын хороо гээд хандаагүй газар байхгүй, шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа, мөн Сонгинохайрхан дүүргийн 62 дугаар сургуулийн захирлаар ажиллаж байгаад халагдсан Ш.Сарантуяаг ажилд нь эргүүлэн томилох 3 шатны шүүхийн шийдвэр гарсан ч биелүүлэхгүй байгаа, Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны даргаар ажиллаж байгаад чөлөөлөгдсөн Н.Уртнасангийн 2 шатны шүүхийн шийдвэрийн дагуу шийдвэр гүйцэтгэлийн шаардсанаар ажилд нь томилоод маргааш нь дахиад чөлөөлсөн тухай гомдлууд байна/

- Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны Засаг дарга Г.Ганчимэг, 14 хорооны Засаг дарга Ж.Энхзаяа нар 2-3 шатны шүүхээр үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн нь тогтоогдсон ч албан тушаалд нь эргүүлэн томилохгүй байгаа, Баянзүрх дүүргийн 15 хорооны Засаг дарга Г.Гантуяаг өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдлөө өгөхийг тулган шаардаж, заналхийлж байгаа тухай гомдол гаргасан өргөдлүүд байна.

Өргөдлийг Байнгын хорооны дүрэм, УИХ-ын гишүүдийн салбар хариуцан ажиллах чиг үүргийн хуваарийн дагуу Байнгын хорооны гишүүн О.Баасанхүү, Ж.Батзандан нар судлан танилцуулж байна.

### **Хоёр: Өргөдлүүдийг судлах, мэдээлэл авах чиглэлээр ажилласан байдал**

Байнгын хороонд ирүүлсэн өргөдлүүдийг судлах явцад төрийн байгууллагуудаас холбогдох мэдээллүүдийг авч ажилласан. Үүнд: Төрийн албаны зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний аудитын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам зэрэг байгууллагууд. Үүнээс гадна төрийн албан хаагчийн талаарх статистик тоо, мэдээ, тайлан болон төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсанд байрлуулсан мэдээ, мэдээллийг мөн судлан ажилласан.

Байнгын хороонд ирүүлсэн өргөдлүүдээс хамгийн их хүнийг хамарсан гомдол гаргасан өргөдлүүд Хөдөлмөрийн яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Эрүүл мэнд, спортын яам тэдгээрийн харъяа газруудтай холбоотой байсан тул яамдын удирдлагуудаас тайлбар, мэдээлэл авах, олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор Нээлттэй сонсголыг 2015 оны 4 дүгээр сарын 29-нд зохион байгуулсан. Нээлттэй сонсголд Улсын Их Хурлын 18 гишүүн, Засгийн газрын гишүүн, Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо, Ерөнхий аудитор А.Зангад, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан болон Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын холбогдох албан тушаалтнууд, өргөдөл өгсөн иргэдийн төлөөлөл нийт 46 иргэн оролцсон. Мөн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хөдөлмөрийн сайд С.Чинзориг, Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамба нар тайлбар, мэдээлэл хийж оролцсон. Сайд нарын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж хариулт авсан болно.

Ажлаас үндэслэлгүйгээр чөлөөлсөн талаарх өргөдлүүдийг судлан шийдвэрлэх, Нээлттэй сонсголын үеэр гарсан асуудлуудыг тодруулах, энэ асуудлыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах зорилгоор Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын ерөнхий газар, Сангийн яам зэрэг байгууллагуудаас нэмэлт мэдээлэл авч ажилласан. /Одоогийн байдлаар Төрийн албаны зөвлөл, Сангийн яамнаас хариу ирээгүй байна/

### **Гурав. Дүгнэлт**

Төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүйгээр чөлөөлсөн талаарх өргөдлүүдийг судлахад дараах байдалтай байна:

1.Төрийн албан хаагчийг чөлөөлөх, томилох шийдвэр гаргахдаа Засгийн газар, төрийн байгууллагууд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчиж байна. Үүнд:

а/Засгийн газар 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдөр тогтоол гарган Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргаар Ц.Цэнгэлийг, Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Ганчимэгийг тус тус томилсон байна. Засгийн газар Төрийн нарийн бичгийн дарга нарыг томилохдоо Төрийн албаны тухай, Засгийн газрын тухай, Яамны эрх зүйн байдлын тухай хуулиудын холбогдох заалтууд, Улсын Их Хурлын 2003 оны 13 тоот тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг тус тус зөрчин томилсон байна. Төрийн албаны зөвлөлөөс Засгийн газрын энэ шийдвэрийн талаар Улсын Их Хурлын даргад 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 767 тоотор ирүүлсэн байна. Уг албан тоотоод Засгийн газрын зүгээс хууль зөрчсөн томилгоог удаа дараа хийж байгааг хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу анхааруулга өгөх, сануулах, зөвлөмж хүргүүлэх зэрэг бүхий л арга хэмжээг шат дараалан авч байгаа боловч Засгийн газар тодорхой арга хэмжээ авахгүй байгаа тул Улсын Их Хурлын даргад Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авч өгөхийг хүссэн байна. Улсын Их Хурлын дарга эрхлэх асуудлын дагуу уг асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэх чиглэлийг өгсөн байна.

Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн, халсан, хууль зөрчин томилсон талаарх дүгнэлт, шийдвэрийг гаргаж байгаа ч Засгийн газар, холбогдох төрийн байгууллагууд биелүүлэхгүй байгаа бөгөөд энэ нь Төрийн албаны тухай хуулийн 39.6-ийн "Төрийн албаны төв байгууллагын гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй" гэсэн заалт хэрэгжихгүй байна. Нөгөө талаас Төрийн албаны зөвлөл ч гэсэн хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

б/Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр чөлөөлсөн, халсан талаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт, шүүхийн шийдвэр гарсаар байтал Засгийн газар, төрийн байгууллагууд хэрэгжүүлэхгүй байна. Үүнээс үүдэн албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас улсын төсвөөс үр ашиггүй зардал гарч байгаа ба 2 жилийн хугацаанд төрийн байгууллагаас гаргуулахаар шүүхээр шийдвэрлэсэн мөнгөн дүнгийн хэмжээ нийт **2 тэрбум 055 сая 019 мянга 834 төгрөг** болсон байна. Мөн 2015 оны төсвийн тодотголд **5 тэрбум 378 сая** гаруй төгрөгийг бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлсний тэтгэмжид тусгасан байна. Ажлаас чөлөөлсний тэтгэмжид олгодог 6 сарын цалинтай тэнцэх мөнгө олгогдохгүй байгаа, зарим тохиолдолд зориулалт бусаар ашиглаж байгаа мэдээлэл ч байгаа тул төрийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг Сангийн яам, Үндэсний аудитын ерөнхий газар энэ чиглэлд хяналтаа сайжруулан албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас улсын төсвөөс гаргасан мөнгөн дүнгийн хэмжээг байгууллага тус бүрээр гаргаж, хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх, улсыг хохиролгүй болгох арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

в/Төрийн байгууллагуудын удирдлагууд үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлж байгаагаас гадна хууль зөрчин төрийн албанд томилж байгаа явдал ч их байна. Тухайлбал, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоогийн мэдээлснээр 2015 оны 4

сарын байдлаар 15 яамны хэмжээнд 138 хүнийг гаднаас, төрийн албаны сонгон шалгаруулалтгүй томилсон нь Төрийн албаны тухай хуулийн Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах гэсэн 17 дугаар зүйлийг зөрчсөн байна. Мөн Авлигатай тэмцэх газрын мэдээлснээр Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам -40, Хөдөлмөрийн яам -45, Эрүүл мэнд, спортын яам-4 хүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянуулаагүй томилсон бөгөөд энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийг зөрчсөн байна. Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар холбогдох хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллахгүй байна.

г/Төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдсан, чөлөөлөгдсөн нь шүүхээр тогтоогдсон ч төрийн байгууллагууд шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа нь шүүхийн шийдвэрийг холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ гэсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

Төрийн байгууллагууд шат шатандаа хууль хэрэгжүүлэхгүй байх, хууль зөрчих явдал газар авч байгаа нь ноцтой асуудал бөгөөд Засгийн газар, яам, агентлагуудын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнууд хууль зөрчсөн шийдвэрүүдээ хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих этгээд, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага гэсэн зүйл, заалт хүчин төгөлдөр бүх хуульд байгаа бөгөөд хуулийн дагуу холбогдох этгээдүүд хуулийн хэрэгжилтэд тавих хяналтаа чангатган, хууль тогтоомж зөрчигчид хариуцлага тооцож ажилласан тохиолдолд л хууль зөрчих явдлыг таслан зогсоох боломжтой.

2.Төрийн албаны зөвлөлийн 2014 оны тайланд Засгийн газрын бүтцэд зөвхөн 2014 онд 3 удаа өөрчлөлт, хөдөлгөөн орсон ба энэ нь төрийн бодлого, үйл ажиллагааны залгамж чанар, тогтвортой байх зарчмыг зөрчиж, боловсон хүчний бодлого алдагдаж байна гэсэн байна. Төрийн байгууллагуудын 2014 оны бүтцийн өөрчлөлтөөр 1500-2000 төрийн албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн гэж байгаа бөгөөд тодорхой тоо байхгүй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.2 дахь заалтын дагуу төрийн албаны хүний нөөцийн асуудал эрхэлдгийн хувьд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлаа хангалтгүй гүйцэтгэж гэж үзэх үндэслэлтэй байна.

Мөн Төрийн албаны зөвлөл Монгол Улсын Үндсэн хуульд заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх гэсэн төрийн албаны үндсэн зарчмыг тууштай баримтлан хараат бус бие даасан байгууллагын хувьд Төрийн албаны тухай хуульд зааснаар “төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих, төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсэн тухай маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар **төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл** гаргах” зэрэг бүрэн эрхийнхээ хүрээнд бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна.

Өнөөдрийн байдлаар Төрийн албаны зөвлөл төрийн жинхэнэ албан хаагчийн эрх

зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэж, дүгнэлт, албан тоотыг Засгийн газар, тухайн төрийн байгууллагад хүргүүлэхээс цааш хэтрэхгүй байгаа нь хууль хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгож, ажлын арга барилаа өөрчлөн шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

3.Төрийн албаны тухай хууль салбарын болон бусад хуулиудтай зөрчилдөж байгаа талаар Байнгын хороонд ирүүлсэн өргөдлүүдэд дурдагдаж, Нээлттэй сонсголын үеэр ч мөн яригдсан. Төрийн албаны зөвлөлийн 2014 оны тайланд “**20** шахам хууль, эрх зүйн актаар **110** гаруй ажлын байрны **350** шахам албан хаагчийг томилох, чөлөөлөх эрхийг Засгийн газрын гишүүдэд олгосон нь төрийн алба улс төрөөс ангид байх, ил тод, тэгш байх зарчмуудыг зөрчиж байна” гэсэн дүгнэлт орсон байна.

Тухайлбал: Усны тухай хуулийн 10.1.11-д Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сав газрын захиргааны даргыг томилох, чөлөөлөх гэж заасан бөгөөд Д.Оюунхорол сайдын 2015 оны 2 сарын 27-ны тушаалаар нэг зэрэг 17 сав газрын захиргааны дарга нарыг чөлөөлж үүрэг гүйцэтгэгч нарыг томиллоо гэсэн гомдлыг ирүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 29.3.-д “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө” гэж заасан. С.Чинзориг сайдын тушаалаар 2015 оны 3 сарын 24-ний өдрөөр тасалбар болгон 21 аймаг, 9 дүүргийн 30 хөдөлмөрийн хэлтсийн дарга, 27 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирлуудыг нэг дор хомроглон чөлөөлсөн тухай гомдлыг эдгээр 57 иргэн Байнгын хороонд ирүүлсэн.

Энэ мэтчилэн Боловсролын тухай хуулиар сайд төрийн өмчийн бүх их, дээд сургуулийн захирлыг, аймаг, нийслэлийн Засаг дарга ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг, Архивын тухай хуулийн дагуу архивын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын албаны ахлах байцаагч, байцаагч нарыг томилж, чөлөөлөн гэж заасан байна. Эдгээрээс гадна Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Ойн тухай, Нийгмийн даатгалын тухай, Соёлын тухай зэрэг 20 гаруй хуулиар улс төрийн албан тушаалтан төрийн албан хаагчийг томилж, чөлөөлөхөөр заасан байна.

Байнгын хороонд ирүүлсэн өргөдлүүдийн 50 гаруй хувийг улс төрийн албан тушаалтан болох сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр үндэслэлгүйгээр чөлөөлсөн талаарх гомдол эзэлж байна.

Дээр дурдсанаас харахад Төрийн алба улс төрийн нөлөөлөлд өртсөн хэвээр байгааг харуулж байгаа бөгөөд Улсын Их Хурал ч төрийн албыг улс төрөөс ангид байлгах зарчмыг баталж байгаа хуулиудад баримтлан, зөрчлийг арилгах тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиуд хоорондоо болон салбарын хуулиудтай зөрчилдөж байгаа нь жишээлбэл төсвийн эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллах хүнийг томилох эсхүл чөлөөлөх асуудлаар маргаан үүсэх нөхцөл бүрдүүлж байна гэсэн байна.

## **Дөрөв: Санал**

Дээрх дүгнэлтүүдийг үндэслэн дараах саналыг Байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулж байна. Үүнд:

1.Төрийн албан хаагчийг улс төрийн албан тушаалтан томилж чөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн хууль эрх зүйн орчныг төрийн алба улс төрөөс ангид байх зарчимд нийцүүлэн өөрчлөх чиглэлийг Засгийн газарт өгөх.

Мөн Засгийн газар, яам, агентлагуудын хэмжээнд төрийн албан хаагчдыг үндэслэлгүйгээр чөлөөлсөн, хууль зөрчин томилсон шийдвэрүүдээ хүчингүй болгох, хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт чиглэл өгөх шаардлагатай байна. Байнгын хорооны тогтоолын төслийг хавсаргав.

2. Байнгын хорооны тэмдэглэлээр Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг, мэдээлдэг байгууллагууд болох Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газарт холбогдох хуулиудын хэрэгжилтэд тавих хяналтаа чангатган, хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах чиглэлийг өгч, танилцуулга хүргүүлэх нь зүйтэй.

3.Өргөдлийн байнгын хорооны танилцуулгыг Төрийн байгуулалтын байнгын хороо болон Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, төрийн албаны шинэчлэлийг иж бүрнээр нь хийхтэй холбогдсон санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэгээр ахлуулсан ажлын хэсэгт хүргүүлэх саналтай байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.БААСАНХҮҮ, Ж.БАТЗАНДАН**